

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 12

№ 24/ТУЗ/11

Улаанбаатар хот

“ Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолд
өөрчлөлт оруулах тухай ”

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.10, Компанийн Ногдол ашгийн бодлогын холбогдох заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай”, уг тогтоолд өөрчлөлт оруулсан Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоол болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 3 сарын 12-ны өдрийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №24/ТУЗ/06 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Тогтоолын 3-т заасан “2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор” гэснийг “2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр” гэж өөрчилсүгэй.
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №24/ТУЗ/06 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Ц.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ